МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ**

ДУЛААН БАЙШИН

# "ДУЛААН БАЙШИН - АМИНЫ ОРОН СУУЦНЫ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ"
# АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

| | |
|---|---|
| **Зорилго:** | Засгийн газрын "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 2025 оны 133 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангах;<br><br>Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг иргэдэд сурталчлан танилцуулах; оролцогч байгууллагуудын уялдааг хангах; |
| **Хаана:** | Нийслэлийн төв талбайд |
| **Хэзээ:** | 2025.05.04 - 13:00-19.00<br><br>2025.05.05-07 – 10:00-19:00 |
| **Ерөнхий зохион байгуулагч:** | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам |
| **Хамтран зохион байгуулагч:** | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам<br><br>Эрчим хүчний яам<br><br>Нийслэлийн Засаг даргын тамгын газар<br><br>Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо |
| **Оролцогч байгууллага:** | Салбарын ТББ, Аж ахуй нэгж байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбарын нийт 91 байгууллагын төлөөлөл оролцлоо. |
| **Оролцооны хэлбэр:** | Оролцогч аж ахуй нэгж байгууллагууд: Барилгын салбарт нэвтрүүлж буй дэвшилтэт шинэ техник технологи, инновацын шийдлээ танилцуулах;<br><br>ХББОСЯам: Амины орон сууц, орон сууцжуулалтын бодлого, арга хэмжээг танилцуулах, холбогдох төр, хувийн байгууллагуудын уялдаа хангах;<br><br>БОУАӨЯам: Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дэвшилтэт шинэ техник технологи, инновацын шийдэл нэвтрүүлэгч аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоог хангах;<br><br>Эрчим хүчний яам: Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дэвшилтэт шинэ техник технологи, инновацын шийдэл нэвтрүүлэгч аж ахуй нэгж байгууллага, иргэдийн оролцоог хангах;<br><br>НЗДТГазар: Хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг иргэдэд танилцуулах, ногоон бүсийн зорилтот хэсгийн иргэдийн оролцоог хангуулах (Хэсгийн ахлагч нарыг зохион байгуулалттайгаар оролцуулах) |

## ДУЛААН БАЙШИН- АМИНЫ ОРОН СУУЦНЫ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГИЙН ХӨТӨЛБӨР

| ТӨВ ТАЙЗ | | | |
|---|---|---|---|
| 13:00-14:00 | **Нээлт үг**<br>- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа (5 минут)<br>- Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн (5 минут)<br>- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь(5 минут)<br>- Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар (5 минут)<br>**Урлагийн үзүүлбэр**<br>**Нээлтэд оролцогсод арга хэмжээний үйл явцтай танилцах**<br>**Арга хэмжээний танилцуулга шторк** | | |
| 14:00-19:00 | *(Оролцогч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга)* | | |
| **ДУЛААЛГА, ДУЛААН ХАНГАМЖ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | **УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | **БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | **ТӨРИЙН ДЭМЖЛЭГ, НОГООН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ШИЙДЭЛ** |
| - Дулаалгын материал<br>- Дулаан хангамж<br>- Агаар сэлгэлт<br>- Сэргээгдэх эрчим<br>- Монгол гэрийн дулаалга /шинэ технологи/<br>- Эрчим хүчний хэмнэлтийн шийдэл технологи<br>- Агаар сэлгэлтийн технологи | - Усан хангамж<br>- Ариутгах татуурга<br>- Бохирын шинэ шийдэл<br>- Цэвэр ус, бохирын хоолойн үйлдвэрлэл<br>- Септик танк үйлдвэрлэл<br>- Эрчим хүчний хэмнэлттэй ус халаагч технологийн компани | - Барилгын материал (хийцлэл)<br>- Эрчим хүчний хэмнэлттэй цонх, хаалганы компани<br>- Эрчим хүчний хэмнэлтэй барилгаар дагнасан угсралтын компани<br>- Үндэсний томоохон барилгын материал үйлдвэрлэгчид | - ХААН банк<br>- Төрийн банк<br>- ХАС банк<br>- ХХБанк<br>- ТоС Холбоо<br>- Ногоон санхүүжилтийн хүрээлэн<br>- Монголын даатгалын холбоо |
| **ГАДНА ТАЛБАЙ** | | | |
| Загварын амины орон сууц, бүтээгдэхүүний үзэсгэлэн | | | |

## ТАЛБАЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дулаан байшин- Амины орон сууцны нээлттэй өдөрлөгийг Нийслэлийн төв талбайд байрлах цагаан Асарын дотор болон гадна гэсэн 2 хэсэгт зохион байгууллаа.



## Асар доторх зохион байгуулалт

Асар доторх зохион байгуулалт нь нийт 4 хэсэгт хуваагдаж нийт нийт 82 бүүт зассан. Үүнд:

1. **Барилга, барилгын материалын шийдэл, технологи (А хэсэг)**

Тус хэсэгт барилгын материал (хийцлэл), эрчим хүчний хэмнэлттэй цонх, хаалганы компани, эрчим хүчний хэмнэлттэй барилгаар дагнасан угсралтын компани, үндэсний томоохон барилгын материал үйлдвэрлэгчдээс гадна барилгын дулаалгын төрөл бүрийн материал үйлдвэрлэгч, нийлүүлэгч, импортлогч, технологи нэвтрүүлэгч, нутагшуулагч гэх мэт нийт 26 аж ахуй нэгж байгууллага оролцсон.

Асрын гадна талд арга хэмжээнд оролцож буй байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний үзэсгэлэн зохион байгуулагдсан бөгөөд дотор байгаа аж ахуй нэгж байгууллагаас 8 нь гадна талбайд талбай авч бүтээгдэхүүнээ сурталчилж оролцсон.

А хэсгийн оролцогчид барилгын салбарт нэвтрүүлж буй дэвшилтэт шинэ техник технологи, инновацын шийдлээ танилцуулах, эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах технологийн шийдлүүдийг иргэдэд сурталчлан танилцуулахаас гадна шууд болон шууд бус худалдан авалт хийлээ.

Тус хэсгийн 26 оролцогчид 2025 оны 05 дугаар сарын 4-7-ны өдрийн хооронд дунджаар нэг аж ахуй нэгж байгууллага нь өдөрт нийт 5,000-6,000 ширхэг танилцуулга тараах материал тарааж иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж, шууд болон шууд бус борлуулалт хийсэн байна. Өдөрлөгийн туршид А хэсэгт давхардсан тоогоор 100-150 мянган иргэн, үйлчлүүлэгч нарт мэдээлэл хүргэж ажилласан байна.

Тус хэсэгт дараах хөтөлбөрийн дагуу танилцуулга, шторкийг нэгдсэн тайзны дэлгэц болон тухайн хэсгийн дэлгэцээр гаргаж, тоглуулж танилцуулсан.

| № | Шторк, танилцуулга хийх дараалал, өдрүүд | | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Бүүтийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| | № | 2025.05.04-07 | | | |
| 1 | 1 | Шторк | "Пирамид индастри" ХХК | Гадна болон замаска, будаг, грунт, хөөсөнцөр хавтан, фасадны тор, чулуун будаг, хөөсөнцөрийн цавуу, 1007 цавуу, хөөсөнцөр гоёлын хүрээ хэсэг | A1 |
| 2 | 2 | Шторк | Хосод арвижих ХХК | Дулаан тусгаарлагч материал /нийлмэл дулаалгын материал/ - e-Board | A2 |
| 3 | 3 | Шторк | МАК | евро блок | A4 |
| 4 | 4 | Шторк | МАК | Си төмөр, цонх | A5 |
| 5 | 5 | Шторк | "Сайхан төмөрт" ХХК | Төмөр хийц болон Хөөсөн полистирол (EPS) хавтан | A6 |
| 6 | 6 | Шторк | Бат Сэндвич ХХК | Сэндвич хавтан | A7 |
| 7 | 7 | Шторк | "Нью север" ХХК | Дээврийн керамзит дулаалга /гадаад талбайд давхар/ | A10 |
| 8 | 9 | Шторк | Альфа Капитад Групп ХХК | Оч цахилгаан халаагуурын үйлдвэр /гадаад талбайд давхар/ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | 10 | Шторк | "Монгол базальт" ХХК | Эрдэс чулуун хөвөн хавтан /гадаад талбайд давхар/ | **A20** |
| 10 | 11 | Шторк | "Кореа стандарт" ХХК | Шүршдэг полиуретан хөөс | **A21** |
| 11 | 12 | Шторк | "Энхтэд" ХХК | дулаалгын Хөөсөн полистирол хавтан /гадаа талбайд давхар/ | **A22** |
| 12 | 13 | Шторк | Цонх констракшн ХХК | эрчим хүчний хэмнэлттэй метал цонх | **A23** |
| 13 | 14 | Шторк | "Эко ноос" ХХК | Хонины ноосон дулаалгын материал | **A24** |
| 14 | 15 | Шторк | "Нью ворм" ХХК | XPS хавтан | **A11** |
| 15 | 1 | танилуулга | Сэмүүн-Од ХХК | Sangetsu, Sincol, Kawashima, Tajima брэндийн үйлдвэрлэдэг дрож, AICA, TOTO брэндийн галд тэсвэртэй өндөр стандартын гоёл чимэглэлийн хавтан, DAIKEN брэндийн гипсэн тааз | **A3** |
| 16 | 2 | танилуулга | Зебра Хаус ХХК | Сип хавтан /амины орон сууны зураг төсөл, барилга угсралт - цогц үйлчилгээ/ | **A8** |
| 17 | 3 | танилуулга | Грийн хоме ХХК | СИП хавтангийн үйлдвэр Сип хавтан /амины орон сууны зураг төсөл, барилга угсралт - цогц үйлчилгээ/ /гадаад талбайд давхар/ | |
| 21 | 4 | танилуулга | "Түмэн тулгуур" ХХК | Сэндвич хавтан болон сайдинг хавтан | **A13** |
| 22 | 5 | танилуулга | Десенк Электрик ХХК | Холбоо дохиолол, хяналтын систем | **A14** |
| 23 | 6 | танилуулга | Барилгачин худалдааны төв, Амины орон сууц | Амины орон сууцны шилдэг 100 загвар сэтгүүл | **A15** |
| 24 | 1 | Ярилцлага өгсөн | "Глобал морек групп" | Эрчим хүчний хэмнэлттэй хавтгай хальсан эко халаалт | **A9** |
| 25 | 2 | Ярилцлага өгсөн | Гэгээн өргөө ХХК | Дулаалга, дулаан тусгаарлах материал /хана тааз, дээврийн дулаалгаын эрдэс хөвөн дулаалгын материал | **A12** |
| 26 | 3 | Ярилцлага өгсөн | Галтсүмбэр констракшн ХХК | Захиалгат амины орон сууц, хаус - цогц үйлчилгээ /эрчим хүчний хэмнэлттэй технологи/ | |

Тухайн хэсгийн онцлох бүтээгдэхүүн, технологи, үйлдвэрлэл, шийдлүүд:

**1.1 Шинэлэг барилгын материалын шийдэл, технологи, дотор агаарын чанар:**

- **"Пирамид индастри" ХХК:** Чанарын шаардлага хангасан дэвшилтэд технологи бүхий сүүлийн үеийн бүх төрийн заслын материалыг нэг газраас авахаас гадна гүйцэтгэлийн ажлыг хийлгэх боломжтой Үүнд: гадна болон дотор замаск, будаг, грунт, хөөсөнцөр хавтан, фасадын тор, чулуун будаг, хөөсөнцрийн цавуу, 1007 цавуу, хөөсөнцөр гоёлын хүрээ гэх мэт
- **Хосод арвижих ХХК:** Дулаан тусгаарлагч материал /нийлмэл дулаалгын материал/ - e-Board хавтан. Дулаан тусгаарлах, дулаалгын материал болохоос гадна заслын ажлыг маш их хөнгөвчлөн шинэ технологи;
- **Цонх констракшн ХХК:** Эрчим хүчний хэмнэлттэй металь цонхны шийдэл, технологи, материал, захиалга, нийлүүлэлт;
- **"Глобал морек групп" ХХК:** Эрчим хүчний хэмнэлттэй хавтгай хальсан эко халаалтын шийдэл технологи, материал нь маш сайн халаалтын систем байхаас гадна заслын ажилд маш үзэмжтэй орон зайг бага эзэлсэн шийдэл болж байна.
- **"Эко ноос" ХХК:** “Хонины ноосон дулаалгын материал” дулаан тусгаарлах, дуулаалга, дуу тусгаарлал, засал, гоё чимэглэл, зөөлөн тоглоом гэх мэт үйлдвэрлэдэг

**1.2 Амины орон сууцны иж бүрэн үйлчилгээг буюу мэдээлэл зөвлөгөө өгөх, зураг төсөл, барилга угсралт, инженерийн шийдэл, гадна тохижилт гээд цогцоор нь үзүүлдэг хэд хэдэн байгууллага үйл ажиллагаагаа сурталчлан, зөвлөгөө мэдээлэл өгч өөрсдийн загварын модельтойгоо оролцсон**. Үүнд:

- **Захиалгат амины орон сууц, хаус**: Цогц үйлчилгээ (эрчим хүчний хэмнэлттэй технологи)
- **Галтсүмбэр констракшн ХХК**: Сип хавтан (Амины орон сууны зураг төсөл, барилга угсралт - цогц үйлчилгээ)
- **Зебра Хаус ХХК:** СИП хавтангийн үйлдвэр Сип хавтан (Амины орон сууны зураг төсөл, барилга угсрал, ногоон зээл, хөрөнгө оруулалт, зөвлөгөө мэдээлэл - цогц үйлчилгээ) Гадаад талбайд давхар -Грийн хоме ХХК;
- **Десенк Электрик ХХК**: Холбоо дохиолол, хяналтын систем, гадна дотор гэрэлтүүлэг
- **Барилгачин худалдааны төв:** Амины орон сууцны шилдэг 100 загвар сэтгүүлийн худалдаа, зөвлөгөө мэдээлэл

**1.3 Халаалтын шийдэл:**

- **"Глобал морек групп" ХХК:** Эрчим хүчний хэмнэлттэй хавтгай хальсан эко халаалтын шийдэл технологи, материал нь маш сайн халаалтын систем байхаас гадна заслын ажилд маш үзэмжтэй орон зайг бага эзэлсэн шийдэл болж байна.
- **Альфа Капитад Групп ХХК**:Оч цахилгаан халаагуурын үйлдвэрлэл, шинэ дэвшилтэд технологи, халаалтын системийг шийдэхээс гадна засал ажилд орон зай бага эзлэх, загварлаг, хүссэн загвараараа захиалах боломжтой.

**Оролцогчдын сэтгэгдэл:** “Дулаан байшин - Амины орон сууцны нээлттэй өдөрлөг” арга хэмжээ нь цаг үеэ олсон үр дүнтэй зохион байгуулагдсанаас гадна хамгийн чухал нь байршил Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж байгаагаараа иргэд олон нийтэд маш сайн хүрч чадлаа. Мөн өдөрлөгийн бүх зардлыг дааж барилгын салбарын, барилгын үйл ажиллагаанд оролцогч талуудыг, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, үйлдвэрлэгч, технологи нэвтрүүлэгч, хөгжүүлэгч, импортлогч гээд маш олон жижиг дунд аж ахуй нэгж байгууллага хамруулж чадлаа. Дахин зохион байгуулах уу, ер нь давтамжтай энэ арга хэмжээг хийж өгөөч гол нь талбайн байршил болоод хэвлэл, мэдээлэл маш чухал байлаа гэсэн сэтгэгдлүүд их ирлээ. Тус өдөрлөгийг санаачлагч хэрэгжүүлэгч, хамтран оролцсон бүх байгууллагуудаа баярлалаа. Бүгдэд нь амжилт хүсье. Зарим сэтгэгдлүүдээс дурдвал:

- "Пирамид индастри" ХХК: Бид 6,000 ширхэг тараах материал тарааж маш сайн мэдээлэл өгч тайлбарлаж чадлаа. Маш их баярлалаа дахин энэ арга хэмжээг намар ч юм уу зохион байгуулж өгөхийг хүсч гэж байна . Дахин зохион байгуулах уу, ер нь давтамжтай энэ арга хэмжээг хийж өгөөч гол нь талбайн байршил болоод хэвлэл, мэдээлэл маш чухал байлаа.;
- Сайн байна уу. Дулаан байшин арга хэмжээ сайхан үр дүнтэй зохион байгуулсанд талархаж байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам хамт олон болон зохион байгуулагч нарт маш их баярлалаа. Бид 2,500 орчим тараах материал тарааж олон хүмүүст байшингын дулаалгын талаар мэдээлэл өглөө. Хосод Арвижих ХХК;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны хамт олонд талбай дээр зохион байгуулсан сайхан өдөрлөгти оролцуулсанд талархаж байна. Манайх 700 гаруй танилцуулга тарааж, шууд захиалга авлаа. Хөл хөдөлгөөн их байлаа, маш их баярласан шүү. Бид олон түмэнд эрчим хүчний хэмнэлттэй цонхыг танилцуулж, ойлгуулсандаа баяртай байна. Танай хамт олонд маш их баярлалаа! Цонх констракшн ХХК;

- Өдөрлөгийн арга хэмжээ сайхан үр дүнтэй зохион байгуулсанд үнэхээр талархаж байна. Манай Солонгосын Ондоля брэндийн шалны эко халаалтын тараах материалаа 800 ширхэг хүмүүст тараалаа. Глобал Морек групп ХХК баярлалаа.
- Өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулсанд талархаж байна. Амжилттай оролцлоо. Нийт 600 хүнд тараах материал тарааж, нэрийн хуудсыг 300 ширхэгийг тараалаа! Өөрсдийн хаусны материал хийцлэлийг бодитоор тайлбарлаж хийж гүйцэтгэсэн ажлаа танилцууллаа Галтсүмбэр констракшн ХХК;
- Энэ удаагийн арга хэмжээ нь Дулаан байшин нэртэйгээр зохион байгуулсан нь ард иргэд өөрсдийн байшин барилгаа барих, засварлах, зэрэгт үзэсгэлэнд оролцож буй компаниудаас маш сайн зөвлөгөө авч сэтгэгдэл өндөр байгаа нь хүмүүсийн ам ярианаас сонсож талархаж байна. Өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулсанд талархаж байна. Амжилттай оролцлоо. Нийт 1,500 хүнд тараах материал тарааж, нэрийн хуудсыг 200 ширхэгийг тараалаа.

## 2. Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл, технологи (В хэсэг)

Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл, технологи хэсэгт нийт 27 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. Үүнд:

- Сэргээгдэх эрчим хүчний техник технологи, Газ болон Соронзон орны бойлерын шийдлүүдийг ашиглан дулаан цахилгааны хэмнэлттэй мөн ногоон зээлд хамрагдах боломжтой шийдлүүдийг 16 аж ахуйн нэгж байгууллага өөр өөрсдийн санал болгож буй шийдэл;
- ТоС холбооны ЧИП багц болон Дулаан шийдэл 2 төслийг хэрэгжүүлж буй хоёр байгууллага гадна болон дотор талбайд гэр болон амны орон сууцыг дулаалах хамгийн тохиромжтой хэмнэлттэй цогц шийдэл;
- Дулаалгын материал болон дулаан хуримтлуурын шинэлэг шийдлийг 6 аж ахуйн нэгж байгууллага санал болгож буй шийдлээ тус тус танилцуулав.

Эдгээр байгууллагаас гадна Эрчим хүчний үндэсний төв, УБЦТС ТӨХК, болон УБЦС ТӨХК нар иргэдийн дундах эргэлзээг арилгаж, мэдээ мэдээллээр маш сайн хангаг оролцлоо.

Мөн тус хэсэгт байрлах мэдээллийн хэсэгт оролцогч байгууллагын төлөөллөөс дараах хөтөлбөрийн дагуу иргэдэд танилцуулга хийлээ.

| ЦАГ | СЭДЭВ | ИЛТГЭГЧ БАЙГУУЛЛАГА |
|---|---|---|
| **2025.05.04 /НЯМ ГАРАГ/** | | |
| 13.00-14.00 | Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл технолгийг нэвтрүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны танилцуулга | Оролцогч байгууллагууд |
| **СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | | |
| 14.00-14.10 | Бага чадлын дээврийн нарны систем | Монхорус эрчим ХХК |
| 14.10-14.20 | Байгальд ээлтэй сонголт | Баясалтгөс ХХК |
| 14.20-14.40 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 14.40-14.50 | Моннаран бренд | Эвридэй Ферм ХХК |
| 14.50-15.00 | Өндөр технологид суурилсан ногоон, ухаалаг эрчим хүч | Жи Фовер ХХК |
| 15.00-15.20 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| **ДУЛААЛГА, ДУЛААН ХАНГАМЖИЙН ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | | |

| | | |
|---|---|---|
| 15.20-15.30 | Агаарын эх үүсвэрт дулааны насос | Эко Сквер Энержи Дистрибюшнс ХХК |
| 15.30-15.40 | Дулаан нөөцлөгч халаагуур | Warm max ХХК |
| 15.40-15.50 | Эко Тулгат төхөөрөмж "Утаагүй Улаанбаатар" | Монватт ХХК |
| 15.50-16.10 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 16.10-16.20 | Давхар кабелийн нүүрстөрөгчийн халаалтын хавтан | Тэмүүлэх өндөр ХХК |
| 16.20-16.30 | Барилгын эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүд | Дулаан шийдэл II төсөл |
| 16.30-16.50 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 16.50-17.00 | Нэгэн дээвэр доор хамтдаа | Росторг ХХК АОС-ны борлуулалтын албаны дарга А.Дөлгөөн |
| 17.00-17.10 | Ухаалаг соронзон орны бойлуур | Тэнгис девлопмент групп ХХК |
| 17.10-17.20 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 17.20-19.00 | Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл технологийг нэвтрүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны танилцуулга | Оролцогч байгууллагууд |
| **2025.05.05, 2025.05.07 /ДАВАА, ЛХАГВА ГАРАГ/** | | |
| 10.00-11.00 | Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл технологийг нэвтрүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны танилцуулга | Оролцогч байгууллагууд |
| **ДУЛААЛГА, ДУЛААН ХАНГАМЖИЙН ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | | |
| 11.00-11.10 | Агаарын эх үүсвэрт дулааны насос | Эко Сквер Энержи Дистрибюшнс ХХК |
| 11.10-11.20 | Дулаан нөөцлөгч халаагуур | Warm max ХХК |
| 11.20-11.30 | Эко Тулгат төхөөрөмж "Утаагүй Улаанбаатар" | Монватт ХХК |
| 11.30-11.50 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 11.50-12.00 | Давхар кабелийн нүүрстөрөгчийн халаалтын хавтан | Тэмүүлэх өндөр ХХК |
| 12.00-12.10 | Барилгын эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүд | Дулаан шийдэл II төсөл |
| 12.10-12.30 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 12.30-12.40 | Нэгэн дээвэр доор хамтдаа | Росторг ХХК АОС-ны борлуулалтын албаны дарга А.Дөлгөөн |
| 12.40-12.50 | Ухаалаг соронзон орны бойлуур | Тэнгис девлопмент групп ХХК |
| 12.50-13.10 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 13.10-15.00 | Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл технологийг нэвтрүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны танилцуулга | Оролцогч байгууллагууд |
| **СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | | |
| 15.00-15.10 | Бага чадлын дээврийн нарны систем | Монхорус эрчим ХХК |
| 15.10-15.20 | Байгальд ээлтэй сонголт | Баясалтөгс ХХК |
| 15.20-15.40 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 15.40-15.50 | Моннаран бренд | Эвридэй Ферм ХХК |
| 15.50-16.00 | Өндөр технологид суурилсан ногоон, ухаалаг эрчим хүч | Жи Фовер ХХК |
| 16.00-16.20 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 16.20-19.00 | Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл технологийг нэвтрүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны танилцуулга | Оролцогч байгууллагууд |
| **2025.05.06 /МЯГМАР ГАРАГ/** | | |

| | | |
|---|---|---|
| 10.00-11.00 | Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл технолгийг нэвтрүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны танилцуулга | Оролцогч байгууллагууд |
| **СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | | |
| 11.00-11.10 | Бага чадлын дээврийн нарны систем | Монхорус эрчим ХХК |
| 11.10-11.20 | Байгальд ээлтэй сонголт | Баясалтөгс ХХК |
| 11.20-11.40 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 11.40-11.50 | Моннаран бренд | Эвридэй Ферм ХХК |
| 11.50-12.00 | Өндөр технологид суурилсан ногоон, ухаалаг эрчим хүч | Жи Фовер ХХК |
| 12.00-12.20 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 12.10-15.00 | Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл технолгийг нэвтрүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны танилцуулга | Оролцогч байгууллагууд |
| **ДУЛААЛГА, ДУЛААН ХАНГАМЖИЙН ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | | |
| 15.00-15.10 | Агаарын эх үүсвэрт дулааны насос | Эко Сквер Энержи Дистрибюшнс ХХК |
| 15.10-15.20 | Дулаан нөөцлөгч халаагуур | Warm max ХХК |
| 15.20-15.30 | Эко Тулгат төхөөрөмж “Утаагүй Улаанбаатар” | Монватт ХХК |
| 15.30-15.40 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 15.40-15.50 | Давхар кабелийн нүүрстөрөгчийн халаалтын хавтан | Тэмүүлэх өндөр ХХК |
| 15.50-16.00 | Барилгын эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүд | Дулаан шийдэл II төсөл |
| 16.00-16.20 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 16.20-16.30 | Нэгэн дээвэр доор хамтдаа | Росторг ХХК АОС-ны борлуулалтын албаны дарга А.Дэлгөөн |
| 16.30-16.40 | Ухаалаг соронзон орны бойлуур | Тэнгис девлопмент групп ХХК |
| 16.40-17.00 | АСУУЛТ, ХАРИУЛТ | Илтгэгчид |
| 17.00-19.00 | Дулаалга, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүчний шийдэл технолгийг нэвтрүүлэгч байгууллагуудын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны танилцуулга | Оролцогч байгууллагууд |

### 3. Усан хангамж, ариутгах татуургын шийдэл, технологи (С хэсэг)

Тус арга хэмжээнд нийтийн аж ахуйн салбарын ус хангамж ариутгах татрууга, инженерийн дэд бүтцийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нийт 16 аж ахуй нэгжүүд оролцож ногоон технологиор бүтээгдсэн бараа материал бүтээгдэхүүнээ танилцуулж, оролцлоо.

*Хүснэгт: 1. Ус хангамж ариутгах татуургын шийдэл технологи буюу “С” хэсэгт оролцогсдын жагсаалт мэдээлэл.*

| Хэрэгжүүлэх арга хэмжээ | № | Оролцогсдын нэрс | Үйл ажилла-гааны чиглэл | Бүтүүний дугаар | Холбоо барих утасны дугаар |
|---|---|---|---|---|---|
| **УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН** | 1 | Уорлд Хабитат ХХК | Био ариун цэврийн байгууламж | **C1** | 99116539 |
| | 2 | Даймондсаен ХХК | Эко ариун цэврийн тоноглол | **C2** | 88901818 |
| | 3 | Эколос алтай ХХК | Цэвэрлэх байгууламж | **C3** | 90930233 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ** | 4 | Баухаус ХХК | Цэвэрлэх байгууламж | **C4** | 95958456 |
| | 5 | Мини шийдэл хоршоо ХХК | Жорлонгоо өөрчилье төсөл | **C5** | 80101449 |
| | 6 | Төгс хурц системс ХХК | Цэвэрлэх байгууламж | **C6** | 91988806 |
| | 7 | Блейз Тек ХХК | Халаалтын зуух | **C7** | 88067391 |
| | 8 | Пластик центр ХХК | Бохирын септик | **C8** | 88104308 |
| | 9 | Грандпайн Интерпрайз ХХК | Ус халаагчтай угаалтуур, ус цэвэршүүлэгч | **C9** | 88101274 |
| | 10 | Централ Рич ХХК | Цахилгаан халаагуур | **C10** | 88107662 |
| | 11 | Акватерм ХХК | Сантехникийн бараа материал | **C11** | 99118505 |
| | 12 | Райсинг Девелопмент ХХК | Бохирын септик | **C12** | 96977774 |
| | 13 | Браунс Луд ХХК | Дулаалгын хөвөн | **C13** | 96068783 |
| | 14 | Бөх Тулга ХХК | Агаар сэлгэлт | **C14** | 89114157 |
| | 15 | Ховд Тул ХХК | Цэвэрлэх байгууламж | **C15** | 99116539 |
| | 16 | Төгс байшин констракшн ХХК | Цэвэрлэх байгууламж | **C16** | 80006293 |

Оролцогсод усгүй био ахуйн суултуур, бохирын септик танкнууд, жижиг оврийн зуслан болон ахуйн хэрэгцээнд ашиглах цэвэрлэх байгууламжууд, хаягдал гялгар уут дахин боловсруулж инженерийн шугам сүлжээний худгын иж бүрдэл болон 100% битүүмжтэй бохир хадгалах пластик танк, “phoenix s” брэндийн цахилгаан халаагуур, Баруун европын халаалт, халуун ус цэвэр ус, бүх төрлийн шүүлтүүр, ус зөөлрүүлэгч, бактер үржүүлэгч гэртэй ахуйн бохир, герман цэвэрлэх байгууламж Эко ариун цэврийн тоноглол зэрэг бүтээгдэхүүнийг иргэдэд танилцуулсан.

Мөн тус хэсэгт байрлах мэдээллийн хэсэгт оролцогч байгууллагын төлөөллөөс дараах хөтөлбөрийн дагуу иргэдэд танилцуулга хийлээ.

| ЦАГ | СЭДЭВ | ИЛТГЭГЧ |
|---|---|---|
| **2025.05.04** | | |
| **11:30-12:00** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **12:00-15:30** | ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА. /ШТОРК/ | |
| **15:30-15:40** | НҮХЭН ЖОРЛОНГИЙН ШИНЭЧЛЭЛ, БОХИР УС ЦЭВЭРЛЭХ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ | ХОВД ТУЛ ХХК. др. Д.БАСАНДОРЖ |
| **15:40-16:00** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **16:00-16:10** | УСГҮЙ БИО ЖОРЛОНГИЙН ШИЙДЭЛ | УОРЛД ХАБИТАТ ХХК |
| **16:10-16:30** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **16:30-16:40** | ДЭД БҮТЭЦГҮЙ ЖОРЛОН, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ | ЖОРЛОНГОО ӨӨРЧИЛЬЕ ТӨСЛИЙН САНААЧЛАГЧ Ц.ОЮУНГЭРЭЛ |
| **16:40-17:00** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **17:00-17:10** | ДУЛААН БАРИЛГЫН ҮЙЛДВЭРЛЭЛ | ПРОМ МЕТАЛЛ ХХК ЗАХИРАЛ БЯМБАСҮРЭН |
| **17:10-17:30** | | |

| | | |
|---|---|---|
| **17:30-17:40** | БОХИРДЛООР БОХИРДЛИЙГ ШИЙДЭХ ШИЙДЭЛ | ПЛАСТИК ЦЕНТР ХХК. МАРКЕТИНГ МЕНЕЖЕР Г. ДАВААНЯМ. |
| **17:40-18:00** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **18:00-19:00** | ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА. /ШТОРК/ | |
| **2025.05.05, 2025.05.07-НЫ ӨДРҮҮДЭД** | | |
| **10:00-11:00** | ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА. /ШТОРК/ | |
| **11:00-11:10** | НҮХЭН ЖОРЛОНГИЙН ШИНЭЧЛЭЛ, БОХИР УС ЦЭВЭРЛЭХ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ | ХОВД ТУЛ ХХК. др. Д.БАСАНДОРЖ |
| **11:10-11:30** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **11:30-11:40** | УСГҮЙ БИО ЖОРЛОНГИЙН ШИЙДЭЛ | УОРЛД ХАБИТАТ ХХК |
| **11:40-12:00** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **12:00-15:00** | ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА. /ШТОРК/ | |
| **15:00-15:10** | ДЭД БҮТЭЦГҮЙ ЖОРЛОН, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ | ЖОРЛОНГОО ӨӨРЧИЛЬЕ ТӨСЛИЙН САНААЧЛАГЧ Ц.ОЮУНГЭРЭЛ |
| **15:10-15:30** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **15:30-15:40** | ДУЛААН БАРИЛГЫН ҮЙЛДВЭРЛЭЛ | ПРОМ МЕТАЛЛ ХХК ЗАХИРАЛ БЯМБАСҮРЭН |
| **15:40-16:00** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **16:00-16:10** | БОХИРДЛООР БОХИРДЛИЙГ ШИЙДЭХ ШИЙДЭЛ | ПЛАСТИК ЦЕНТР ХХК. МАРКЕТИНГ МЕНЕЖЕР Г. ДАВААНЯМ. |
| **16:10-16:30** | АСУУЛТ, ХАРИУЛТ | ЗОХИОН БАЙГУУЛАГЧ |
| **16:30-19:00** | ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА. /ШТОРК/ | |





## 4. Төрийн дэмжлэг, ногоон хөрөнгө оруулалт (D хэсэг)

Тус хэсэгт нийт 14 бүүт засагдаж төрийн байгууллага 2; Төрийн бус байгууллага 2; банк санхүүгийн 6, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага 1 нийт 11 байгууллага оролцлоо.

*Хүснэгт: 2. Төрийн дэмжлэг, ногоон хөрөнгө оруулалт буюу D хэсэгт оролцогсдын мэдээлэл*

| Хэрэгжүүлэх арга хэмжээ | № | Оролцогсдын нэрс | Үйл ажилла-гааны чиглэл | Бүүтний дугаар | Холбоо барих утасны дугаар |
|---|---|---|---|---|---|
| ТӨРИЙН ДЭМЖЛЭГ, НОГООН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 1 | Ногоон барилгын хүрээлэн ТББ | ТББ | **D1** | 99113058 |
| | 2 | Амины орон сууцны мэдээллийн төв | Мэдээллийн төв | **D2** | 99992844 |
| | 3 | Монгол даатгал | Даатгал | **D3** | 99998302 |
| | 4 | Бодь даатгал | Даатгал | **D4** | 99050847 |
| | 5 | Эрчим хүчний яам | Төрийн байгууллага | **D5** | 99030632 |
| | 6 | Эрчим хүчний яам | Төрийн байгууллага | **D6** | 91911203 |
| | 7 | НЗДТГазар | Төрийн байгууллага | **D7** | 86116661 |
| | 8 | НЗДТГазар | Төрийн байгууллага | **D8** | 86116661 |
| | 9 | Хас | Банк | **D9** | 99944344 |
| | 10 | Хас | Банк | **D10** | 99944344 |
| | 11 | ХХБ | Банк | **D11** | 99133466 |
| | 12 | Хаан | Банк | **D12** | 99016158 |
| | 13 | Төрийн банк | Банк | **D13** | 99102395 |
| | 14 | ШУТИС-БАС | Эрдэм шинжилгээ, сургалт | **D14** | 99906665 |

### 4.1. Төрийн байгууллага:

Тус арга хэмжээнд Эрчим хүчний яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар бүүтэд сууж үйл чиглэлийн дагуу хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэдэд танилцуулав. Үүнд:

- *Эрчим хүчний яам:* Иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг төрийн үйлчилгээ буюу тусгай зөвшөөрөл болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг түргэн шуурхай, нээлттэй, хүндрэлгүй байдлаар шийдвэрлэлтийг бүрэн цахимд шилжүүлсэн талаар танилцуулгыг хийж ажилласан.
- *НЗДТГазар:* Иргэдэд өөрийн амьдарч гэр болон амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулах дулаалгын шийдлийн талаар

### 4.2. Төрийн бус байгууллага:

Тус арга хэмжээнд Ногоон барилгын хүрээлэн; Амины орон сууцны мэдээллийн төв (*Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв*)-үүд өөрийн байгууллага үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаар танилцуулга хийлээ.

- *Ногоон барилгын хүрээлэн:* Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтран Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр боловсруулж батлуулсан үндэсний “BestGER” үнэлгээний аргачлал болон ногоон барилгын аудитор бэлтгэх сургалтын талаар мэдээлэл иргэдэд өглөө.
- *Амины орон сууцны мэдээллийн төв (Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв):* Төр хувийн хэвшлийн түншлэлээр тус яам нь Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төвтэй хамтран "Амины орон сууцны мэдээллийн төвийн

үйл ажиллагааг иргэд олон нийтэд таниулан үйл ажиллагаагаа эхлүүлж нийт 3 байршилд нээгээд байна. Тус төв нь барилгын салбарт нэвтэрч буй сүүлийн үеийн дэвшилтэт технологийн шийдлүүд, ногоон зээл олгогч банк санхүүгийн байгууллага зэрэг олон талын оролцогчид нэг дороос эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгатай холбоотой бүхий л үйлчилгээг иргэд олон нийт гүйцэтгэгчид, төсөл хэрэгжүүлэгчдэд зөвлөгөө мэдээлэл хүргэж буй талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажиллалаа. Нийт мэдээлэл, зөвлөгөө зөвлөмж авсан иргэдийн 50% нь амины орон сууцаа сайжруулах, 10-20% нь амины орон сууц шинээр барихаар төлөвлөж буй иргэд байлаа.

### 4.3. Банк санхүүгийн байгууллага:

Тус арга хэмжээнд Төрийн банк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Монгол даатгал, Бодь даатгал гэсэн банк, санхүүгийн байгууллага оролцож өөрийн байгууллагын амины орон сууцны ногоон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулав. Өдөрлөгийн үеэр 20 иргэн зээл судлуулсан хэдий ч зээлийн гэрээ байгуулаагүй байна.

- *Худалдаа хөгжлийн банк*: Иргэдэд хэрэглээний ногоон зээл, эрчим хүчний хэмнэлттэй хувийн орон сууц барих, худалдах авах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцууллаа.

*Хүснэгт: 3. Хэрэглээний ногоон зээл:*

| Бүтээгдэхүүний нөхцөл | Иргэн |
|---|---|
| Зээлийн хэмжээ | 50.0 сая ₮ хүртэл |
| Зээлийн хүү | Жилийн 15.0% (Сарын 1.25%) |
| Зээлийн хугацаа | 30 сар хүртэл |
| Худалдан авалтын урьдчилгаа төлбөр | 0% |
| Барьцаа хөрөнгө | Дансны орлого, ирээдүйд олох орлого |
| Зээлийн үйлчилгээний шимтгэл | Шимтгэлгүй |

*Хүснэгт: 4. Эрчим хүчний хэмнэлттэй хувийн орон сууц барих, худалдан авах зээл:*

| Урьдчилгаа төлбөрийн хэмжээ | Зээлийн хүү | Хугацаа | Зээлийн үйлчилгээний шимтгэл | Хэмжээ |
|---|---|---|---|---|
| 30%-иас дээш | Жилийн 16.2% (сарын 1.35%) | 20 жил хүртэл | Зээлийн дүнгээс - 0.8% (1,000,000 ₮ хүртэл) | 1 тэрбум ₮ хүртэл |

- *Хаан банк:* Иргэдэд ногоон зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцууллаа.

*Хүснэгт: 5. Ногоон зээл:*

| Зээлийн нөхцөл | Төгрөг |
|---|---|
| Зээлийн хэмжээ: | 50 сая хүртэл төгрөг |
| Зээлийн хугацаа: | 30 хүртэл сар |
| Зээлийн хүү* /жилийн/: | 15.0% |
| Урьдчилгаа төлбөр: | 0% |
| Зээлийн өргөдлийн хураамж: | 0 төгрөг |

| | |
|---|---|
| Зээл олгох үйлчилгээний шимтгэл: /Олгосон зээлийн дүнгийн/ | 1% буюу 1.5 сая төгрөг. Доод хэмжээ 1000 төгрөг. |
| Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа: | 1000 төгрөг (Гуравдагч талын төлбөр) |
| Хөдлөх хөрөнгийн барьцаа бүртгэлийн лавлагаа: | 20,000 төгрөг, өөрчлөлт оруулах бол 10,000 төгрөг (Гуравдагч талын төлбөр) |

- *Хас банк:* Иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээл, *Chip багц төслийн* зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцууллаа.

*Хүснэгт: 6. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээл:*

| Нөхцөл | Амины орон сууц бариулах | Хотхоны орон сууц худалдан авах |
|---|---|---|
| Зээлийн хэмжээ | 400 сая төг. хүртэл | |
| Дээд хугацаа | 240 сар | |
| Доод хугацаа | 6 сар | |
| Жилийн хүү | 12% | |
| Зээл хүсэгчээс төлөх урьдчилгаа төлбөр | 20% | |
| Байршил | Хязгаарлалтгүй | |
| АОС-ны талбай, м2 | Хязгаарлалтгүй | |
| Өргөдлийн хураамж: | 0 төг. | |
| Үйлчилгээний шимтгэл | Урьдчилгаа 20% бол шимтгэл 0.5%<br>Урьдчилгаа 20%-аас дээш бол шимтгэлгүй | |
| Түр барьцаа | Зээлийн хэмжээ 200,000,000 төгрөгөөс дээш бол хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө шаардана. | Үл хөдлөх эд хөрөнгө шаардана. |

*Хүснэгт: 7. Chip багц төслийн зээл:*

| | |
|---|---|
| Зээлийн хэмжээ | 3,200,000 төгрөг<br>*/Энэ нь багц бүтээгдэхүүний үндсэн үнэ бөгөөд тодорхой шаардлага хангасан иргэдэд үндсэн үнийн дүнгээс 50-70% хөнгөлөлттэй* үнээр олгох боломжтой./* |
| Зээлийн хүү | Жилийн 15.6% |
| Зээлийн хугацаа | 30 сар |
| Үйлчилгээний шимтгэл | 1% |

- *Төрийн банк:* Иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц худалдан авах зээл, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих зээл, амины орон сууцыг эрчим хүчний хэмнэлт бий болгох зорилгоор засварлах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцууллаа.

*Хүснэгт: 8. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц худалдан авах зээл:*

| Зээлийн нөхцөл | Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц худалдан авах |
|---|---|

| | | |
|---|---|---|
| Зээлийн хэмжээ | | 500.0 сая төгрөг хүртэл |
| Зээлийн хүү(жилийн) | 20%-40% Эрчим хүчний хэмнэлт | 16.80% |
| | 41%-60% Эрчим хүчний хэмнэлт | 15.60% |
| | 61%-иас дээш Эрчим хүчний хэмнэлт | 14.40% |
| Урьдчилгаа | | 20% |
| Зээлийн хугацаа | | 240 сар хүртэл |
| Зээл олгох үйлчилгээний шимтгэл | | Зээл олгох үйлчилгээний шимтгэл: олгосон зээлийн 1%, 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй. |
| Нэмэлт | | Орон сууц нэмэлтээр барьцаалсан тохиолдолд урьдчилгаа төлбөрийн хэмжээ 0% байж болно. |
| Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсны шимтгэл | | Зээлийн үлдэгдлийн 1.%, 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй. |

*Хүснэгт: 9. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих зээл:*

| **Зээлийн нөхцөл** | | **Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, хашаа байшин барих** |
|---|---|---|
| Зээлийн хэмжээ | | 500.0 сая төгрөг хүртэл |
| Зээлийн хүү(жилийн) | 20%-40% Эрчим хүчний хэмнэлт | 16.80% |
| | 41%-60% Эрчим хүчний хэмнэлт | 15.60% |
| | 61%-иас дээш Эрчим хүчний хэмнэлт | 14.40% |
| Урьдчилгаа | | 20% |
| Зээлийн хугацаа | | 240 сар хүртэл |
| Зээл олгох үйлчилгээний шимтгэл | | Зээл олгох үйлчилгээний шимтгэл: олгосон зээлийн 1%, 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй |
| Нэмэлт | | Орон сууц нэмэлтээр барьцаалсан тохиолдолд урьдчилгаа төлбөрийн хэмжээ 0% байж болно |
| Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсны шимтгэл | | Зээлийн үлдэгдлийн 1 %, 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй. |

*Хүснэгт: 10. Амины орон сууцыг эрчим хүчний хэмнэлт бий болгох зорилгоор засварлах зээл:*

| Зээлийн нөхцөл | | Амины орон сууцыг эрчим хүчний хэмнэлт бий болгох зорилгоор засварлах |
|---|---|---|
| Зээлийн хэмжээ | | 50.0 сая төгрөг хүртэл |
| Зээлийн хүү(жилийн) | 20%-40% Эрчим хүчний хэмнэлт | 16.80% |
| | 41%-60% Эрчим хүчний хэмнэлт | 15.60% |
| | 61%-иас дээш Эрчим хүчний хэмнэлт | 14.40% |
| Урьдчилгаа | | 0% |
| Зээлийн хугацаа | | 120 сар хүртэл |
| Зээл олгох үйлчилгээний шимтгэл | | Зээл олгох үйлчилгээний шимтгэл: олгосон зээлийн 1%, 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй |
| Нэмэлт | | Орон сууц нэмэлтээр барьцаалсан тохиолдолд урьдчилгаа төлбөрийн хэмжээ 0% байж болно |
| Гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулсны шимтгэл | | Зээлийн үлдэгдлийн 1%, 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй |

Мөн тус хэсэгт байрлах мэдээллийн хэсэгт оролцогч байгууллагын төлөөллөөс дараах хөтөлбөрийн дагуу өдөрт 2 удаагийн давтамжтай иргэдэд танилцуулга хийж ажиллалаа.

| № | Хугацаа | Танилцуулгын нэр | Илтгэгч |
|---|---|---|---|
| 1. | 14:00-14:20<br>16:00-16:20 | Bestger ногоон барилгын үнэлгээний систем | Монголын ногоон барилгын хүрээлэн Гүйцэтгэх захирал **Ц.Батгэрэл** |
| 2. | 14:20-15:00<br>16:20-17:00 | Хотын монгол гэр | Пассив барилгын хүрээлэн гүйцэтгэх захирал **А.Амарбаяр** |
| 3. | 15:00-15:20<br>17:00-17:20 | Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төлөвлөлт | Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төвийн Гүйцэтгэх захирал **А.Отгончимэг** |






## 5. Виртуал хэсэг

Сонгинохайрхан дүүрэгт байрлах Амины орон сууцны мэдээллийн төвийг бүрэн цахим болгон виртуал хэлбэрт шилжүүлэн, иргэдэд дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор танилцуулга видео, байгууллагуудын мэдээллүүд, түгээмэл асуулт, хариултууд, 40 гаруй нэг маягийн зургийг үнэгүй татаж ашиглах боломжтой болгож гар утас, таблет, компьютер төхөөрөмжнөөс орж мэдээлэл авах боломжтой болгосон.

Мөн Эрчим хүчний хэмнэлттэй ногоон амины орон сууцуудыг VR төхөөрөмж ашиглан хана, тааз, шал, цонх, бохирын системийн шийдлүүд, хийц бүтээцийн мэдээллүүдийг харах, байшин дотор нь орж үзэх боломжтой болгож иргэдэд танилцууллаа.

"АМИНЫ ОРОН СУУЦ" ӨДӨРЛӨГИЙН АСРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГ



## Асрын гадна талын зохион байгуулалт

Асрын гадна талд арга хэмжээнд оролцож буй байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний үзэсгэлэн зохион байгуулагдсан бөгөөд нийт 15 аж ахуй нэгж байгууллага оролцохоор төлөвлөж байсан боловч аж ахуй нэгжийн хувийн бэлтгэл ажил хангагдаагүйн улмаас “Мон-Арк ХХК өдөрлөгт оролцож чадаагүй. Мөн цаг агаарын байдал хүйтэн сэрүүн салхитай байснаас шалтгаалан 5 байгууллага дотор талбайруу шилжин өдөрлөгт оролцсон. Гадна талбайд нийт 9 байгууллага гадна талбайд оролцсон.

Е хэсэг-Гадна талбай

| № | Байгууллагын нэр | Лого | Үйл ажиллагаа | Баталгаажсан | Шторк | Танилцуулга | Талбайн хуваарлалт | Талбайд байршуулах |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Пассив барилгын хүрээлэн | PASSIVE HOUSE MONGOLIA | | Баталгаажсан | Байхгүй | ирүүнэ | E12 | Загастай байшин |
| 2 | Монгол базальт | | | Баталгаажсан | Гандолгор | Гандолгор | E1 | Загварын байшин 3х3х4.5 |
| 3 | Одкон сервис энд ко ХХК | | Шатаадаг жорлон, Хэт улаан туяаны цахилгаан халаагуур | Баталгаажсан | Лхагвад өгсөн | байхгүй | E3 | Загварын байшин 2х2 |
| 4 | Агаар нэг төсөл | | Монгол гэрийн дулаалга | Баталгаажсан | Лхагвад өгсөн | ирүүнэ | E4 | Монгол гэр |
| 5 | "Мөнх Тайж Алтай" ХХК | МӨНХ ТАЙЖ АЛТАЙ | "Greenwarm" цахилгаан халаагуур Монгол гэрийн дулаалга | Баталгаажсан | ирүүнэ | байхгүй | E5 | Монгол гэр |
| 6 | ИНТЕРЛОК БЛОК ххк | | Барилгын дэвшилтэт өрөгт бүтээц материал | Баталгаажсан | ирүүнэ | ирүүнэ | E11 | |
| 7 | Пром Металл ХХК | | Дулааны хэмнэлттэй орон сууцны үйлдвэр | Баталгаажсан | ирүүнэ | ирүүнэ | E2 | Загварын байшин 7х4х3.5 |
| 8 | Грийн хоме ХХК | Green home | СИП хавтангийн үйлдвэр | Баталгаажсан | Гандолгор | Гандолгор | E15 | Асар |
| 9 | Хаан Зиндаа ХХК | ХААН | Хөнгөн жинтэй хөөсөн бетон, Эрчим хүчний хэмнэлттэй Дотор гоёл [illegible] | Баталгаажсан | Лхагвад өгсөн | ирүүнэ | E16 | Асар 5х5 |

## ОРОЛЦОГЧ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дулаан байшин- Амины орон сууцны нээлттэй өдөрлөгт оролцогч аж ахуй нэгж байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгаанд нийт оролцогсдын 75.8% буюу 69 аж ахуй нэгж байгууллага хамрагдсан байна.

Тус өдөрлөгийн зохион байгуулалтад судалгаанд хамрагдагсдын 42% нь сайн, 42% нь боломжийн, 15.9% нь сайжруулах шаардлагатай гэсэн үнэлгээ өгчээ. Сайжруулах шаардлагатай гэсэн үнэлгээ өгсөн оролцогсод нь цахилгаан, гэрэлтүүлэг, халаалт, бүүт засаж буй байгууллагын зохион байгуулалт зэргийг сайжруулах шаардлага байна гэж үзсэн байна.

**Өдөрлөгийн зохион байгуулалт ямар байсан бэ?**



Тус өдөрлөгт нийт 10,000 орчим, давхардсан тоогоор 29,562 иргэн хамрагджээ. Судалгаанд хамрагдагсдын 59.4% нь 300 хүртэлх; 13% нь 301-600; 2.9% нь 601-900; 8.7% нь 901-1,200; 15.9% нь 1,201 дээш иргэнд өдөрлөгийн үеэр мэдээлэл, зөвлөгөө зөвлөмж өгсөн байна.

**Энэхүү өдөрлөгийн үеэр нийт хэдэн иргэнд мэдээлэл, зөвлөмж өгсөн бэ?**




Судалгаанд хамрагдагсад өдөрлөгийн үеэр 241 ажил үйлчилгээ үзүүлэх, худалдах гэрээ, 187 бараа, бүтээгдэхүүний худалдаа хийсэн байна. Өдөрлөгийн үеэр хийсэн борлуулалтын дүнгээр нь авч үзвэл 64.3% нь 5 сая хүртэлх; 14.3% нь 5-10 сая хүртэл; 3.6% нь 10-15 сая хүртэл; 17.9% нь 15 саяаас дээш төгрөгийн борлуулалт хийжээ.

**Өдөрлөгийн үеэр хичнээн төгрөгний борлуулалт хийсэн бэ?**



Цаашид тус арга хэмжээг тогтмол зохион байгуулахыг дэмжиж байгаа эсэх асуултад нийт оролцогсдын 88.6 дэмжсэн хариулт өгчээ.




Тус арга хэмжээг хэдэн өдөр зохион байгуулбал үр дүнтэй гэж бодож байна вэ? гэсэн асуултад нийт оролцогсдын 2.6% нь 1 өдөр, 5.1% нь 2 өдөр, 51.3% нь 3 өдөр, 17.9% нь 4 өдөр, 23.1% нь 4-с дээш өдөр гэж хариулжээ.




## ЦААШИД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ДЭЭР АНХААРАХ ЗҮЙЛС:

- Цаг агаарын нөхцөл байдлыг урьдчилан тооцож, арга хэмжээ авах;
- Буут угсрах байгууллагын туршлага, хүний нөөц боломжийг нарийвчлан судлан үзэж, гэрээ байгуулах;
- Цахилгааны ачааллыг нарийвчлан тооцож эх үүсвэрийг бий болгох.

**АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, САНАЛ ЗӨВЛӨМЖ:**

- “Дулаан байшин - Амины орон сууцны нээлттэй өдөрлөг” нь 2025 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Нийслэлийн төв талбайд зохион байгууллаа.
- Тус өдөрлөгт салбарын төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбарын нийт 91 байгууллагын төлөөлөл оролцож нийт 10,000 орчим, давхардсан тоогоор 29,562 иргэнд эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг танилцууллаа.
- Оролцогч байгууллагууд нь 241 ажил үйлчилгээ үзүүлэх, худалдах гэрээ; 187 бараа, бүтээгдэхүүний худалдаа хийсэн байна.
- Хэсгүүдэд байрлах мэдээллийн хэсэгт нийт 31 илтгэл, өдөрт дунджаар 2 удаагийн давтамжтай танилцуулагдлаа.
- Нэгдсэн мэдээллийн дэлгэцээр нийт 75 аж ахуй нэгж байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга шторк өдөрт дунджаар 3 удаагийн давтамжтай танилцуулагдлаа.
- Сонгинохайрхан дүүрэгт байрлах Амины орон сууцны мэдээллийн төвийг бүрэн цахим болгон виртуал хэлбэрт шилжүүлэн, иргэдэд дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор танилцуулга видео, байгууллагуудын мэдээллүүд, түгээмэл асуулт, хариултууд, 40 гаруй нэг маягийн зургийг үнэгүй татаж ашиглах боломжтой болгож гар утас, таблет, компьютер төхөөрөмжөөс орж мэдээлэл авах боломжтой болгосон.
- Эрчим хүчний хэмнэлттэй ногоон амины орон сууцуудыг VR төхөөрөмж ашиглан хана, тааз, шал, цонх, бохирын системийн шийдлүүд, хийц бүтээцийн мэдээллүүдийг харах, байшин дотор нь орж үзэх боломжтой болгож иргэдэд танилцууллаа.
- Амины орон сууцны мэдээллийн төв *(Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв)-өөс* мэдээлэл, зөвлөгөө зөвлөмж авсан иргэдийн 50% нь амины орон сууцаа сайжруулах, 10-20% нь амины орон сууц шинээр барихаар төлөвлөж буй иргэд байсан байна.
- Өдөрлөгийн хүрээнд 24 сайт, 6 телевизтэй хамтран ажиллаж, 60 гаруй шууд дамжуулалт болон хэвлэлийн мэдээлэл бэлтгэж өдөрлөгийн ач холбогдлыг олон нийтэд түгээсэн байна.
- Урьдчилж зар түгээж хүсэлт ирүүлсэн байгууллагуудаас сонгон шалгаруулж оролцогсдын жагсаалт гаргах
- Арга хэмжээг амралтын өдрүүдэд зохион байгуулах.

Танилцсан:

СХОСБЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — Ц.Адъяабаатар

Хянасан:

СХОСБЗГ-ын Орон сууцжуулалтын хэлтсийн дарга — Э.Батболд

Боловсруулсан:

СХОСБЗГ-ын Орон сууцжуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн — С. Бужмаа

**ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ ЭНДЭЭС ТАТАЖ АВНА УУ.**